



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 9/889

Улаанбаатар хот

Э.Мөнхтуулд сахилгын  
шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.13, 48 дугаар зүйлийн 48.1.3 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/291 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд тэмдэг хэрэглэх журам"-ын 7.1, 7.2 дахь хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/1300 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Улсын бүртгэлийн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам"-ын 10.6, 10.8 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн 11 дүгээр хорооны улсын бүртгэгч Энхтайваны Мөнхтуул эрхэлсэн ажилдаа хайнга хандаж, улсын бүртгэгчийн тэмдгийг хаяж, үрэгдүүлсэн тул түүнд албан тушаалын цалингийн хэмжээг 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн 3 сарын хугацаагаар 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хэрэгжүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг улсын бүртгэгч Э.Мөнхтуулд үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс /П.Мөнхбаатар/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

*Д. Дэлгэрсайхан (Мөнхтуул)*  
*Бүсдэд сангдсан,*  
*хэрэгжилтэд хяналт*  
*М/Б/7.*